



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2022/5-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Сүхбаатар сум 2022 он	Тэргүүлэх аудитор:	Ч.Энхтуяа
	Утас: 7036-3040	Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn
	Аудитын менежер:	Б.Батмөнх
	Утас: 7036-3036	Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn
	Аудитор:	З.Золбоо
	Утас: 7036-2442	Цахим хаяг: Zolbooz@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Агуулга

1. Аудитын санал, дүгнэлт	3
2. Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	6
3. Аудитын тайлан.....	10
3.1. Ерөнхий зүйл	10
3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4. Материаллаг байдал.....	12
3.5. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт.....	13
3.5.1. Мөнгөн хөрөнгө.....	13
3.5.2. Авлага	13
3.5.3. Бараа материал	14
3.5.4. Үндсэн хөрөнгө	15
3.5.5. Өр төлбөр	16
3.5.6. Засгийн газрын хувь оролцоо.....	16
3.5.7. Орлогын данс	16
3.5.8. Зарлагын данс.....	17
3.6. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар тодруулга	18
3.6.1 Төсвийн төлөвлөлт	20
3.6.2 Төсвийн гүйцэтгэл	21
3.6.3 Нэмэлт төсөв.....	22
3.7. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	22
3.8. Аудитын гол асуудал	23
3.9. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал....	23
3.9.1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	23
3.9.2. Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт.....	24
3.10. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	25
3.11. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	26
4. Аудитын илрүүлэлт	26
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	33

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗГ	Засгийн газар
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХС	Сум хөгжүүлэх сан
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЗШ	Тусгай зориулалтын шилжүүлэг
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
УИХ	Улсын Их Хурал
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ШШГГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМТ	Эрүүл мэндийн төв



ЗҮҮНБҮРЭН СУМЫН ЗАСАГ ДАРГА
Э.САРАНБААТАР ТАНАА

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.03.25 № СЭА-2022/5-НА-СТА-ТТЗ

танан _____ ны № _____

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Зүүнбүрэн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Зүүнбүрэн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- **Сумын ИТХ:** Хурлын нарийн бичгийн дарга Ж.Нямсүрэнд 200.0 мянган төгрөгийн албан томилолтын зардлыг давхардуулан олгосон.
- **Сумын ЗДТГ:** Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон 3 албан хаагчид нийт 1,700.1 мянган төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламжийг илүү олгосон,
- **Сумын ЭМТ:**
 - Ковид-19 өвчний шинжилгээний төлбөрийн орлогын тооцоог тухай бүр хийж баталгаажуулаагүйгээс 3,082.0 мянган төгрөг, эмийн

сангийн борлуулалтын орлогын 899.4 мянган төгрөг зэрэг 13,331.4 мянган төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн байна.

- Магадлан итгэмжлэлийн хугацааг сунгуулаагүй, ЭМДС-аас санхүүжилт аваагүйгээс шалтгаалан эм хангамжийн байгууллагуудад 5,697.7 мянган төгрөгийн эмийн төлбөрийн өр төлбөр үүсгэсэн,
- Тайлант оны эмийн батлагдсан төсвийг хэтрүүлснээс 7,484.2 мянган төгрөгийн, ЭМДС-аас санхүүжилт авч чадаагүйгээс Ковид 19 багцын 3,665.2 мянган төгрөгийн зэрэг нийт 11,149.4 мянган төгрөгийн эмийг харьяа эмийн сангаас авсан боловч төлбөрийг барагдуулаагүй,
- Жолоочийн тооцооны хуудас хөтлөлгүйгээр буюу анхан шатны баримтын бүрдэлгүйгээр нийт 5,907.5 мянган төгрөгийн шатахууны зарлагын гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан,
- Хөнгөлөлттэй эмийн жор зөрүүтэй бичигдсэнээс шалтгаалж ЭМДС-аас 647.1 мянган төгрөгийн санхүүжилт дутуу авсан,
- Дарга О. Халиуны эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацаа дууссан байхад тайлант оны 9-12 дугаар саруудад их эмчийн албан тушаал хавсран ажилласны 837.7 мянган төгрөгийн нэмэгдэл цалин олгосон,
- Эмийн сангийн 16,434.0 мянган төгрөгийн кассын орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд орлого орсон тухай бүр бус бөөн дүнгээр төвлөрүүлсэн,
- Ажлын байрны тодорхойлолтод заасан ажил үүргээ гүйцэтгэсэн дарга О.Халиун /их эмч хавсран ажилласан/-д “Нэмэгдэл хөлс тооцож олгох” хуудсаар баталгаажаагүй илүү цагийн хөлс тооцож, нийт 5,899.3 мянган төгрөг олгосон байна.

- **Сумын Соёлын төв:** Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон 2 албан хаагчид 1,681.7 мянган төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламжийг илүү олгосон байна.

Эдгээр зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 35 дугаар зүйлийн 35.2, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, ЗГ-ын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, 2019 оны 7 дугаар тогтоолын 2.1, 3.1, Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалын 1-р хавсралтын 3.12 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	448,907.10	574,378.40
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	54,890.60	197,151.20
33	АВЛАГА	153,178.40	115,524.30
35	БАРАА МАТЕРИАЛ	240,838.10	261,702.90
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,436,783.00	5,965,145.60
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,436,783.00	5,965,145.60
39200	Биет хөрөнгө	5,343,129.20	5,870,991.80
39300	Биет бус хөрөнгө	93,653.80	94,153.80
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,885,690.10	6,539,524.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	14,861.90	5,697.70
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	14,861.90	5,697.70
41300	Өглөг	14,861.90	5,697.70
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,870,828.20	6,533,826.30
51	Засгийн газрын хувь оролцоо	5,870,828.20	6,533,826.30
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,797,431.60	1,797,431.60
51200	Хуримтлагдсан үр дүн	1,649,096.50	2,312,094.60
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,424,300.10	2,424,300.10
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,885,690.10	6,539,524.00

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,705,145.80	3,414,768.80
11	ТАТВАРЫН ОРЛОГО	107,457.50	162,394.00
110	Орлогын албан татвар	53,205.00	44,955.40
1100	Хувь хүний орлогын албан татвар	53,205.00	44,955.40
113	Хөрөнгийн албан татвар	1,080.00	7,651.00
118	Бусад татвар, төлбөр, хураамж	53,172.50	39,787.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,812,182.20	823,428.20
120	Нийтлэг татварын бус орлого	1,812,182.20	823,428.20
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,785,506.00	2,428,946.60
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,106,269.90	2,681,565.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,106,269.90	2,681,565.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,251,602.10	2,464,030.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,411,569.50	1,455,557.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	173,998.10	186,710.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	199,230.00	244,518.40
2104	Хангамж, бараа материалын зардал	67,882.50	63,013.80
2105	Нормативт зардал	98,201.70	146,761.40

Зүүнбүрэн сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,979.10	33,487.20
2107	Томилолт, зочны зардал	2,990.20	1,739.30
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,009.90	25,812.80
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	263,741.10	306,429.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	854,667.80	217,535.30
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,598,875.80	723,203.40
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	55,221.00	70,205.30
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	1,543,654.80	662,998.10

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,914,656.60	2,677,073.30
11	ТАТВАРЫН ОРЛОГО	107,457.50	162,394.00
110	Орлогын албан татвар	53,205.00	44,955.40
1100	Хувь хүний орлогын албан татвар	53,205.00	44,955.40
113	Хөрөнгийн албан татвар	1,080.00	77,651.00
118	Бусад татвар, төлбөр, хураамж	53,172.50	39,787.60
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	11,064.60	9,870.30
1181	Газрын төлбөр	39,137.90	27,316.00
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	2,970.10	2,601.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	21,693.00	85,732.70
120	Нийтлэг татварын бус орлого	21,693.00	85,732.70
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,785,506.00	2,428,946.60
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,843,972.70	2,400,189.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,843,972.70	2,400,189.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,989,900.50	2,182,654.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,409,179.70	1,455,625.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	175,953.10	186,642.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	199,124.00	244,518.40
2104	Хангамж, бараа материалын зардал	49,425.70	53,382.80
2105	Нормативт зардал	80,373.50	140,866.10
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,089.90	34,478.00
2107	Томилолт, зочны зардал	2,990.20	1,739.30
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,798.50	31,940.80
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,965.90	33,461.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	854,072.20	217,535.30
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	70,683.80	276,883.40
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	77,247.10	97,622.40
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	77,247.10	97,622.40
2200	Дотоод эх үүсвэрээр	77,247.10	97,622.40
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(77,247.10)	(97,622.40)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-	(37,000.40)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	37,000.00
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	-	0.40

Зүүнбүрэн сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(6,563.20)	142,260.70
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	61,453.80	54,890.60
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	54,890.60	197,151.20

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,327,173.40	-	4,327,173.40
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,327,173.40	-	4,327,173.40
4	Тайлант үеийн үр дүн	1,543,654.80	-	1,543,654.80
5	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,870,828.20	-	5,870,828.20
6	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5,870,828.20	-	5,870,828.20
7	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
8	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,870,828.20	-	5,870,828.20
9	Тайлант үеийн үр дүн	662,998.10	-	662,998.10
10	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	6,533,826.30	-	6,533,826.30

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,376,499.40	2,270,929.69	105,569.71	95.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,215,316.70	2,116,204.91	99,111.79	95.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,491,076.50	1,440,220.78	50,855.72	96.59
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	198,949.70	184,717.06	14,232.64	92.85
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	248,313.00	244,518.38	3,794.62	98.47
2104	Хангамж, бараа материалын зардал	45,797.00	42,784.35	3,012.65	93.42
2105	Нормативт зардал	118,595.60	93,664.00	24,931.60	78.98
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	56,468.50	56,468.47	0.03	100.00
2107	Томилолт, зочны зардал	2,761.30	1,739.30	1,022.00	62.99
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,920.40	18,657.88	1,262.53	93.66
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,434.70	33,434.70	-	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	161,182.70	154,724.78	6,457.92	95.99

Зүүнбүрэн сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2132	Бусад урсгал шилжүүлэг	161,182.70	154,724.78	6,457.92	95.99
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	69,686.40	68,623.75	1,062.65	98.48
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	183,988.20	37,000.00	146,988.20	20.11
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,445,699.30	1,402,488.81	43,210.49	97.01
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	955,730.90	921,852.19	33,878.71	96.46
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	28,636.50	1,325.27	27,311.23	4.63
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	200,107.30	81,670.06	118,437.24	40.81
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	956.00	1,505.00	(549.00)	157.43
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	7.00	7.00	-	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	126.00	126.00	-	100.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	697.00	697.00	-	100.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	529.00	529.00	-	100.00
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	168.00	168.00	-	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	126.00	126.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Дүн
21	УРСГАЛ ЗАРДАЛ	115,048.31
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	95,448.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	15,404.62
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,925.58
2104	Хангамж, бараа материалын зардал	10,945.21
2105	Нормативт зардал	47,202.07
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,661.44
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,282.89
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	115,048.31
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	28,082.65
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	24,609.94
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	40,236.22

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын төсвийн төвлөрүүлэн захирагч /Зүүнбүрэн сумын ТТЗ гэх/-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд зардлыг бодит тооцоо судалгаан дээр үндэслэж, үнэн зөв төлөвлөж, хэрэгжүүлж байх, төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг бүртгэж байх, бараа материалын үлдэгдлийг зөв ангилан, залруулж бүртгэх, арилжааны банкинд төлбөрийн картын данс нээлгэж бэлэн мөнгө шилжүүлэн авч зарцуулж байх зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор З.Золбоо гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Зүүнбүрэн сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 1/43 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Зүүнбүрэн сумын ТТЗ-ийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг “*Өрхийг дэмжсэн өсөлтийн бодлого*” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийг хэрэгжүүлэх, сурталчлах, биелэлтийг нь хангах ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах үндсэн дээр хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, мал сүргийг өсгөн үржүүлэх, малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг, үржлийн ажлыг зохион байгуулах, байгалийн гэнэтийн аюул, мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэрэгжүүлэх,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах,

- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын, түүнчлэн бүс нутгийн чанартай үйлдвэрлэл, үйлчилгээ, нийгэм-соёлын зориулалттай барилга байгууламж барьж байгуулахад орон нутгийн болон хувийн хөрөнгө оруулалт хийх ажлыг дэмжиж, зохион байгуулах,
 - Төрийн ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах,
 - Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн ИТХ-д оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
 - Нутаг дэвсгэрийнхээ татварын орлогыг хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах,
 - Төрийн болон тухайн орон нутгийн өмчийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- 1 Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,
- 2 Малын тоо толгойн албан татварын тухай хууль 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс шинээр мөрдөгдөхөөр батлагдсан,
- 3 Малын тоо толгойн албан татварын тухай хуультай холбоотойгоор 2020 онд Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр 60 дугаар зүйлийн 60.2.8-д малын тоо толгойн албан татварын орлогыг зарцуулах заалт шинээр нэмэгдсэн,
- 4 Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлд заасан Төрийн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах хэсэгт 2021 оны 7 дугаар сард нэмэлт өөрчлөлт оруулсан,
- 5 УИХ-аас 2021 оны 6 дугаар сард Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан даатгуулагчийн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн доод хэмжээ нь Засгийн газраас баталсан тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тэтгэврийн даатгалд 11.5 хувиас, тэтгэмжийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд тус бүр 1.0 хувиас багагүй байна гэж өөрчлөлт оруулсан,
- 6 Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 2021 оны 43 дугаар тогтоолоор төсөвт зардлыг хэмнэх, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах шаардлагыг төсвийн бүх шатны байгууллагын төсөв захирагч нарт даалгасан,
- 7 Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах “Босго үнэ шинэчлэн батлах тухай” журмыг баталсан,

- 8 Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам” шинэчлэгдэн батлагдсан,
- 9 Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам” шинэчлэгдэн батлагдсан,
- 10 Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” шинэчлэгдсэн,
- 11 Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн,
- 12 Аймгийн ТЕЗ-ийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан гэх мэт.

Зүүнбүрэн сумын ТТЗ-ийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дээд шатны төсвийн захирагчаас дотоод аудит хийгдээгүй байна.

ТТЗ-ийн удирдлагын зүгээс тайлант онд хэрэгжүүлсэн дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй гэж үзэж байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Зүүнбүрэн ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 2,681,565.5 мянган төгрөгөөс 1.5 хувиар тооцон **40,223.5** мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 30,167.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл **54,890.6** мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл **197,151.2** мянган төгрөг болж, **142,260.6** мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө	-	-	-	-
Банканд байгаа бэлэн мөнгө	54,890.6	197,151.2	142,260.6	72.1
Замд яваа мөнгөн хөрөнгө	-	-	-	-
Хадгаламж	-	-	-	-
Дүн	54,890.6	197,151.2	142,260.6	72.1

Эх сурвалж: Зүүнбүрэн сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд тайлагнагдсан 130,393.0 мянган төгрөг орон нутгийн ерөнхий орлогын дансанд, 1,062.7 мянган төгрөг ОНХС-ийн дансанд, 64,847.0 мянган төгрөг СХС-ийн дансанд, 848.5 мянган төгрөг нь ЭМТ-ийн / Ковид-19 цар тахалтай холбогдолтойгоор үлдэгдлийг татан төвлөрүүлээгүйгээс/ дансанд тус тус байршиж байна

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 153,178.4 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 115,524.3 мянган төгрөг болж, 37,654.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага			
Төлбөртэй үйлчилгээний авлага			
Татаас, санхүүжилтийн авлага			
Зээлийн хүүгийн авлага	3,344.7	2,595.1	(749.6)
Бусад авлага	860.1	-	(860.1)
Зээлийн авлага	148,973.6	112,929.2	(36,044.4)
Дүн	153,178.4	115,524.3	(37,654.1)

Эх сурвалж: Зүүнбүрэн сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай /нийт/ 115,524.3 мянган төгрөгийн дараах авлага байна. Үүнд:

- СХС-ийн зээлийн хүүгийн 2,132.6 мянган төгрөгийн авлага,
- СХС-ийн зээлийн 74,929.2 мянган төгрөгийн авлага байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг барагдуулахаар зээлдэгч нарт мэдэгдэх хуудас өгч ажилласан байна.

СХС-аас 2011-2013 онд зээл авсан 3 иргэний нийт 6,192.0 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн авлага барагдуулах үйл ажиллагааг аймгийн ШШГГ-аас явуулж байх хугацаанд сумын Засаг даргаас “ ... зээлээ төлж барагдуулсан тул гүйцэтгэх хуудсыг хааж өгнө үү” гэсэн хүсэлтийг албан бичгээр хүргүүлж, гүйцэтгэх ажиллагааг зогсоосноос шалтгаалж тус зээлүүд өнөөг хүртэл эргэн төлөгдөж дуусаагүй байна. Энэ нь СХС-ийн зээлийн үлдэгдэлд найдваргүй авлага үүсэх, СХС-ийн эргэлтийг удаашруулах, эх үүсвэр дутагдах эрсдэлийг үүсгэж байна.

3.5.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 240,838.1 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 261,702.9 мянган төгрөг болж, 20,864.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	32,870.2	37,263.5	4,393.3
Эм боох материал	31,100.4	18,015.6	(13,084.8)
Бэлэн бүтээгдэхүүн	-	-	-
Бичиг хэргийн материал	9,491.4	12,365.1	2,873.7
Аж ахуйн материал	78,851.0	98,319.3	19,468.3
Сэлбэг хэрэгсэл	-	1,752.0	1,752.0
Барилгын засварын материал	2,501.8	-	(2,501.8)
Хүнсний материал	-	120.4	120.4
Бусад хангамжийн материал	86,023.3	93,867.0	7,843.7
Дүн	240,838.1	261,702.9	20,864.8

Эх сурвалж: Зүүнбүрэн сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд бараа материалын данс нь 353,303.1 мянган төгрөгийн материал худалдан авсан, 33,995.7 мянган төгрөгийн материал хандиваар хүлээн авсан, 5,108.1 мянган төгрөгийн материалыг шилжүүлэн авсан дүнгээр нэмэгдэж, сумын ОНХС-ийн эх үүсвэрээр бэлтгэсэн 79,886.8 мянган төгрөгийн бараа материалыг ашиглагч байгууллагад шилжүүлсэн, 290,407.5 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан, 1,247.8 мянган төгрөгийн бараа материалыг акталсан дүнгээр хорогдсон байна.

Аудитын илрүүлэлт:

Дараах байгууллагууд нь бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна Үүнд:

- ИТХ нь 2,127.8 мянган төгрөгийн,
- ЗДТГ нь 27,427.8 мянган төгрөгийн,
- Соёлын төв нь 2,382.6 мянган төгрөгийн,
- ЭМТ нь 67,417.3 мянган төгрөгийн,
- Цэцэрлэг 1,375.2 мянган төгрөгийн,
- ЕБС 5,737.7 мянган төгрөгийн гэх мэт.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл / анхны өртгөөр / 6,446,645.2 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 6,856,268.2 мянган төгрөг болж, 409,623.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл / анхны өртгөөр /

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	4,908,843.3	4,902,570.9	(6,272.4)
Авто-тээврийн хэрэгсэл	284,079.5	284,079.5	-
Машин тоног төхөөрөмж(компьютер)	401,429.7	437,077.6	35,647.9
Тавилга, аж ахуйн эд хогшил	197,389.1	206,472.0	9,082.9
Зам, гүүрийн байгууламж	52,384.1	250,104.9	197,720.8
Бусад үндсэн хөрөнгө	468,461.6	638,026.9	169,565.3
Ном	39,904.1	43,784.2	3,880.1
Програм хангамж	500.0	500.0	-
Бусад биет бус хөрөнгө	93,653.8	93,653.8	-
Дүн	6,446,645.2	6,856,268.8	409,623.6

Эх сурвалж: Зүүнбүрэн сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгийн данс /анхны өртгөөр/ 409,623.6 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 28,998.6 мянган төгрөг, хандиваар 12,803.7 мянган төгрөг, шилжүүлэн авсан 408,179.0 мянган төгрөг зэрэг нийт 449,981.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн, сумын ИТХ-ын 2021 оны 58 дугаар тогтоолоор цэцэрлэг, сургуулийн нийт 40,357.7 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данс бүртгэлээс хассан зэргээс тус тус шалтгаалсан байна.

3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 14,861.8 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 5,697.7 мянган төгрөг болж, 9,164.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Бараа, үйлчилгээний зардлын өглөг	14,861.5	5,697.7	(9,163.8)	(160.8)
Байгууллагад төлөх өглөг	0.3	-	(0.3)	-
Дүн	14,861.8	5,697.7	(9,164.1)	(160.8)

Эх сурвалж: Зүүнбүрэн сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа, үйлчилгээний зардлын өглөгийн үлдэгдэлд ЭМТ-ийн 5,697.7 мянган төгрөгийн эмийн өглөг тайлагнагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

- ЭМТ нь магадлан итгэмжлэлийн хугацааг сунгуулаагүй, ЭМДС-аас санхүүжилт аваагүйгээс шалтгаалан эм хангамжийн байгууллагуудад 5,697.7 мянган төгрөгийн эмийн төлбөрийн өр төлбөр үүсгэсэн байна.

3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 5,870,828.2 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 6,533,826.3 мянган төгрөг болж, 662,998.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 6 Засгийн газрын хувь оролцоо

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,797,431.6	1,797,431.6	-	-
Өмнөх үеийн үр дүн	105,441.7	1,649,096.5	1,543,654.8	93.6
Тайлант үеийн үр дүн	1,543,654.8	662,998.1	(880,656.7)	(132.8)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,424,300.1	2,424,300.1	-	-
Дүн	5,870,828.2	6,533,826.3	662,998.1	10.15

Эх сурвалж: Зүүнбүрэн сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5.7 Орлогын данс

Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого буюу ЗДТГ-ын байрыг Төрийн банкинд түрээслүүлсний 7,847.9 мянган төгрөг, ЕБС-ийн сурах бичгийн түрээс 328.0 мянган төгрөг, ЭМТ-ийн эмийн сангийн 16,434.0 мянган төгрөг зэрэг нийт 24,609.9 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

3.5.8 Зардлын данс

Зардлын данстай холбоотой 48,996.9 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

ИТХ:

- ИТХ-ын нарийн бичгийн дарга Ж.Нямсүрэнд **200.0** мянган төгрөгийн албан томилолтын зардлыг давхардуулан олгосон.

ЗДТГ:

- Тайлант онд "Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн буцалтгүй тусламж"-ийг 3 албан хаагчид олгохдоо тухайн албан хаагчийн 36 сарын албан тушаалын үндсэн цалингийн дунджийг зөрүүтэй тооцоолсноос нийт **1,700.1** мянган төгрөг илүү олгосон,

Цэцэрлэг:

- Эрхлэгч Х.Өлзийсайханд улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг 2, 4 дүгээр улиралд 51-54 хувиар тооцон **183.3** мянган төгрөгийг илүү олгосон.

ЕБС:

- Захирал Ц.Уранбодолд улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг 2,4 дүгээр улиралд 58-59 хувиар тооцож, **375.4** мянган төгрөгийг илүү олгосон.

ЭМТ:

- ЭМТ нь төлбөр тооцоог тухай бүр хийж баталгаажуулаагүйгээс Ковид-19 өвчнийг илрүүлэх оношлуурын 3,082.0 мянган төгрөг, эмийн сангийн 899.4 мянган төгрөгийн эмийн орлого, хөнгөлөлттэй эмийн жор зөрүүтэй бичигдсэнээс шалтгаалж 647.1 мянган төгрөгийн ЭМДС-ийн санхүүжилтийн эмийн орлого зэрэг нийт **4,628.5** мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн.
- Тайлант оны батлагдсан төсвийн хүрээнд аймгийн ЭМГ-аас тендерийн эмийг хүлээн авч зарцуулсан атал эмийн батлагдсан төсвийг хэтрүүлж 7,484.2 мянган төгрөгийн, ЭМДС-аас санхүүжилт авч чадаагүйгээс Ковид 19 -ын багцын 3,665.2 мянган төгрөгийн зэрэг нийт **11,149.4** мянган төгрөгийн эмийг харьяа эмийн сангаас авсан боловч төлбөрийг барагдуулаагүй,
- Өмнөх оны зөвлөмжийг хэрэгжүүлээгүй буюу тайлант оны эмийн сангийн **16,434.0** мянган төгрөгийн кассын орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд орлого орсон тухай бүр бус бөөн дүнгээр төвлөрүүлсэн,
- ЭМТ-ийн дарга нь тайлант оны 9-12 дугаар саруудад эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацаа дууссан байхад их эмчийн албан тушаал хавсран ажилласны **837.7** мянган төгрөгийн нэмэгдэл цалин олгосон,
- Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг биелүүлэлгүйгээр зөрчлийг давтан гаргаж, "Нэмэгдэл хөлс тооцож олгох " хуудсаар баталгаажуулаагүй болон

албан тушаалын ажлын байрны тодорхойлолтод заасан ажил үүргээ гүйцэтгэсэн дарга О.Халиун /*их эмч хавсран ажилласан*/-д **5,899.3** мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдэл хөлс олгосон, жолоочийн тооцооны хуудасгүй нийт **5,907.5** мянган төгрөгийн шатахуун зарцуулсан. / *Үүнээс дарга О.Халиунд 4,204.5 мянган төгрөгийн дизель түлш олгосон* /

Соёлын төв:

- Төрийн албаны ТҮ-ангилал зэрэглэлийн албан тушаалд ажиллаж байгаад “Хөдөлмөрийн гэрээ” -гээр ажиллаж байсан 2 албан хаагчийн “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн буцалтгүй тусламж”-ийг олгохдоо гэрээт ажилтнаар ажилласан хугацааг төрийн албанд ажилласан хугацаанд тооцож нийт **1,681.7** мянган төгрөг илүү олгосон.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Сумын ИТХ-ын 2021 оны 08 сарын 09-ний өдрийн 19 дүгээр тогтоолоор “Зүүнбүрэн сумын 2021 оны төсөв тодотгон батлах”, тайлант оны татварын орлогыг 56,442.0 мянган төгрөгөөр, татварын бус орлогыг 13,500.0 мянган төгрөгөөр, нийт 69,942.0 мянган төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 166,240.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 137.7 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт 7. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татварын орлого	56,442.0	162,394.0	105,952.0	287.7
Үйл ажиллагааны орлого	7,600.0	10,992.9	3,392.9	144.6
Хөрөнгийн орлого	19,770.0	24,847.7	5,077.7	125.7
Хөрөнгө борлуулсны орлого	1,500.0	9,114.8	7,614.8	6.0 дах
Бууны албан татвар	1,150.0	1,505.0	355.0	130.9
Малд ногдуулах албан татвар	-	76,146.0	76,146.0	-
Улсын тэмдэгтийн хураамж	3,000.0	1,774.6	(1,225.4)	59.2
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	3,000.0	4,845.6	1,845.6	161.5
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	3,000.0	3,250.0	250.0	108.3
Газрын төлбөр	12,748.0	24,200.5	11,452.5	189.8
Дуудлага худалдаа	2,000.0	3,115.5	1,115.5	155.8
Ойн нөөц ашигласны төлбөр	-	273.6	273.6	-
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	254.0	10.0	(244.0)	3.9
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	-	20.0	20.0	-

Зүүнбүрэн сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	2,420.0	2,297.7	(122.3)	94.9
Татварын бус орлого	13,500.0	3,846.5	(9,653.5)	28.5
Хүү, торгуулийн орлого	6,000.0	3,301.5	(2,698.5)	55.0
Бусад орлого	7,500.0	545.0	(6,955.0)	7.3
Нийт дүн	69,942.0	166,240.5	96,298.5	237.7

Эх сурвалж: Зүүнбүрэн сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн орлогын төлөвлөгөө давж биелэхэд үйл ажиллагааны орлого 3,392.9 мянган төгрөг, хөрөнгийн орлого 5,077.7 мянган төгрөг, хөрөнгө борлуулсны орлого 7,614.8 мянган төгрөг, газрын төлбөр 11,452.5 мянган төгрөгөөр давж биелсэн нь голлон нөлөөлсөн байна.

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний давсан болон тасарсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

Давж биелсэн орлогууд:

- Үйл ажиллагааны орлого: Тайлант онд хувиараа хадлан бэлтгэгчдийн өвсний борлуулалт нэмэгдэж, хувь хүний орлогын албан татвар төлснөөс шалтгаалсан,
- Хөрөнгийн орлого: Тайлант онд тус сумын харьяа иргэдийн хугацаатай хадгаламж нэмэгдсэнээс шалтгаалж орлогын төлөвлөгөө давж биелсэн,
- Хөрөнгө борлуулсны орлого: Иргэдийн эзэмшиж, өмчилж буй газар болон үл хөдлөх хөрөнгийн борлуулалт өссөнөөс шалтгаалсан,
- Бууны албан татвар: Өмнөх онд төлүүлэхээр ногдуулсан албан татварын орлогыг тайлант онд төвлөрүүлсэн,
- Малд ногдуулах албан татвар: Малын тоо толгойн албан татварын тухай хууль 2021 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд тус албан татварын төлөвлөгөөг сумын төсөвт батлаагүй боловч 76,146.0 мянган төгрөгийн орлого төвлөрсөн,
- Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр: Суманд зам арчлалттай холбоотойгоор замын ажлууд хийдсэнтэй холбоотойгоор төлөвлөгөө давсан,
- Хог хаягдлын үйлчилгээний хураамж: ЗГ-ын 2020 оны 211 дүгээр тогтоолоор айл өрхийн энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг төрөөс хариуцан төлөх болсноос шалтгаалж тус хураамжийн төлөвлөгөөг багаар баталсан болон өмнөх оны төлөгдөөгүй үлдэгдлийг төвлөрүүлснээс шалтгаалсан,
- Газрын төлбөр: Орлого төлөвлөгөөнөөс давж биелсэн,
- Дуудлага худалдааны орлого: Дуудлага худалдаагаар зарагдсан газар төлөвлөсөн үнэ/дуудлага худалдааны анхны үнэ/-с илүү үнээр зарагдсанаас шалтгаалсан,
- Ойн нөөц ашигласны төлбөр: Орлого төлөвлөөгүй бөгөөд тайлант онд малчдаар ойн цэвэрлэгээ хийлгэж, түлш бэлтгүүлсний төлбөр төвлөрүүлснээс шалтгаалсан.

Тасарсан орлого:

- Улсын тэмдэгтийн хураамж: Иргэдийн бичиг баримтыг баталгаажуулах нотариатын төлбөр болон газрын гэрчилгээний тэмдэгтийн хураамжийн орлого ковид-19 цар тахлын улмаас иргэдийн үйлчлүүлэх тоо буурснаас шалтгаалсан,
- Ан амьтны нөөц ашигласны төлбөр: Иргэд ан амьтан агнах хүсэлт гаргаагүйгээс уг орлого тасарсан,
- Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр: Байгалийн жимс хаврын улиралд орсон их бороонд цохиулж жимслээгүйгээс шалтгаалсан,
- Хүү, торгуулийн орлого: Татварын улсын байцаагчийн ногдуулсан торгууль төлөвлөсөн хэмжээнээс багассанаас шалтгаалсан,
- Бусад орлого: Тус сумын хэмжээнд Зөрчлийн тухай хуулийн хүрээнд гардаг зөрчил буурснаас ногдуулах торгууль буурсан байна.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,665,238.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2,665,238.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Сумын ИТХ-ын 2020 оны 18 дугаар тогтоолоор төсвийн орлогыг 87,342.0 мянган төгрөг, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогоос 7,232.0 мянган төгрөг, эхний үлдэгдлээс санхүүжих 18,915.2 мянган төгрөг, аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 800,653.7 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 61,220.0 мянган төгрөг, ТЗШ-ийн байгууллагын санхүүжилтийг 1,443,449.0 мянган төгрөг, ЭМДС-аас санхүүжүүлэх шилжүүлгийг 28,636.5 мянган төгрөг, ОНХС-ийн өмнөх оны үлдэгдлээс 8,466.4 мянган төгрөг, СХС-ийн урд оны үлдэгдэл 27,408.9 мянган төгрөг, СХС-ийн зээлийн эргэн төлөлт 157,000.0 мянган төгрөг зэрэг нийт 2,640,323.7 мянган төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2021 оны 19 дүгээр тогтоолоор аймгийн 2021 оны төсвийг тодотгосонтой холбогдуулан сумын ИТХ-ын 2021 оны 08 дугаар сарын 09-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор татварын болон татварын бус орлогоос 69,942.0 мянган төгрөг, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогоос 7,232.0 мянган төгрөг, эхний үлдэгдлээс санхүүжих 18,915.2 мянган төгрөг, аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 805,653.7 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 61,220.0 мянган төгрөг, ТЗШ-ийн байгууллагын санхүүжилтийг 1,444,230.1 мянган төгрөг, ЭМДС-аас санхүүжүүлэх шилжүүлгийг 28,636.5 мянган төгрөг, ОНХС-ийн урд оны үлдэгдлээс 8,366.4 мянган төгрөг, СХС-ийн урд оны үлдэгдэл 27,508.9 мянган төгрөг, СХС-ийн зээлийн эргэн төлөлт 157,000.0 мянган төгрөг, эргэлтийн эмийн сангийн орлогыг 50,000.0 мянган төгрөг зэрэг нийт **2,678,704.8** мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр эцэслэн баталсан байна.

Үүнээс ТЗШ-ийн байгууллагуудад 1,472.866.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс ТЗШ-ийн байгууллагуудад 245,903.3, ИТХ-д 62,152.4 мянган төгрөг, ЗДТГ-д

503,877.2 мянган төгрөг, соёлын төвд 139,810.0 мянган төгрөг, ОНХС-д 69,686.4 мянган төгрөг, СХС-д 184,408.9 мянган төгрөгийн зэрэг нийт **2,678,704.8** мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөсөн байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/372 дугаар захирамжаар ТЗШ-ийн байгууллагуудын төсөвт зохицуулалт хийгдэж, сумын төсөв **2,630,174.0** мянган төгрөг болж өөрчлөгдсөн байна.

Сумын төсөвт ИТХ-ын 2021 оны 08 дугаар сарын 09-ны өдрийн 19 дугаар тогтоолоор дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Орон нутгийн татварын болон татварын бус орлогыг 17,400.0 мянган төгрөгөөр бууруулж, наадмын зардлын 5,000.0 мянган төгрөгөөр, соёлын төвийн батлагдсан төсвийг 12,400.0 мянган төгрөгөөр бууруулсан,
- Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын тогтмол зардлыг 12,876.2 мянган төгрөгөөр бууруулж, Засаг даргын нөөц хөрөнгийг ковид 19 цар тахал болон малын гоц халдварт шүлхий өвчний зардлыг санхүүжүүлэхээр 12,876.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгосон,
- Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих ЕБС-ийн санхүүжилтийг 27,120.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, цэцэрлэгийн санхүүжилтийг 26,339.2 мянган төгрөгөөр бууруулсан,
- Аймгаас суманд өгөх санхүүгийн дэмжлэг 5,000.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, ЭМТ-ийн тогтмол зардлыг нэмэгдүүлсэн,
- Нэмэлтээр ЭМТ-ийн эргэлтийн эмийн сангийн орлого, зарлагыг 50,000.0 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 15 хөтөлбөрт зориулан 2,453,081.1 мянган төгрөгийн төсөв батлагдсан боловч сургууль, цэцэрлэгийн батлагдсан төсөвт өөрчлөлт орсноор **2,630,174.0** мянган төгрөгөөр эцэслэн батлагдаж, 2,376,078.7 мянган төгрөгийг урсгал зардалд, урсгал зардалд, 69,686.4 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, СХС-ийн зээлд 184,408.9 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөжээ.

Нийт зардлын 1,445,699.3 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 28,636.5 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 805,653.7 мянган төгрөгийг аймгаас авах санхүүгийн дэмжлэгээс, 69,842.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 18,915.2 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс, 7,232.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 157,000.0 мянган төгрөгийг СХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс, 27,508.9 мянган төгрөгийг СХС-ийн эхний үлдэгдлээс, 61,220.0 мянган төгрөгийг ОНХС-аас, 8,466.4 мянган төгрөгийг ОНХС-ийн эхний үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 1,402,488.8 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 1,325.3 мянган төгрөг, аймгаас авах санхүүгийн дэмжлэг 805,653.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 47,574.6 мянган төгрөг, ОНХС-аас 61,220.0 мянган төгрөг, 7,403.8 мянган төгрөгийг ОНХС-ийн эхний

үлдэгдлээс, үндсэн үйл ажиллагааны орлогоос 7,232.0 мянган төгрөг, СХС-ийн зээлийн эргэн төлөлт 74,438.1 мянган төгрөг зэрэг нийт **2,407,336.3** мянган төгрөгийн санхүүжилтийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **2,376,553.4** мянган төгрөг буюу 90.4 хувьтай тайлагнагдсан нь СХС-аас төлөвлөсөн хэмжээгээр зээл олгоогүй, ТЗШ болон орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилтийг гүйцэтгэлээр санхүүжүүлсэн болон харьяа байгууллагуудын төсвийн хэмнэлтээс шалтгаалсан байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулбал цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, ажил олгогчийн НДШ-ийн зардал нийт 65,088.4 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 3,794.6 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардал 3,012.6 мянган төгрөгөөр, нормативт зардал 24,931.6 мянган төгрөгөөр, томилолтын зардал 1,022.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 1,262.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Тайлант онд сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх 1 төсөл, арга хэмжээнд 69,686.4 мянган төгрөгийн санхүүжилт батлагдаж 68,623.8 мянган төгрөгийн санхүүжилт олгон, 1,062.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчдын 28,082.7 мянган төгрөг, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 5,000.0 мянган төгрөг, хандив 17,119.5 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 24,609.9 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 40,236.2 мянган төгрөг зэрэг нийт 115,048.3 мянган төгрөгийн нэмэлт орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардалд 15,404.6 мянган төгрөг, НДШ-д 1,925.6 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардалд 10,945.2 мянган төгрөг, нормативт зардалд 47,202.1 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 6,661.4 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжид 13,282.9 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 26.5 мянган төгрөг, урсгал шилжүүлэгт 19,600.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

3.7.1 Аудитын цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан Зүүнбүрэн сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд тусгагдсан 449,982.3 мянган төгрөгийн шинээр нэмэгдэж, бүртгэгдсэн хөрөнгүүдийг биетээр тулган

баталгаажуулах боломжгүй байсан тул эдгээр хөрөнгийн ашиглалт, шинж байдалд ТТЗ-ийн зүгээс хяналт хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй.

3.7.2 2019 онд өндөр насны тэтгэвэр тогтоолгож, төрийн албанаас чөлөөлөгдсөн албан тушаалтнаар Санхүүгийн албаны даргын албан тушаалыг “ Хөдөлмөрийн гэрээ”-ний үндсэн дээр өнөөг хүртэл гүйцэтгүүлж, түүний шууд хяналт тавьж ажиллах сумын төрийн сангийн мэргэжилтний албан тушаалыг хавсруулан гүйцэтгүүлсэн байна.

3.7.3 Сумын онцгой комисс нь Ковид-19 цар тахалтай тэмцэхэд зориулж иргэн, ААНБ-аас хандивласан **1,100.0** мянган төгрөгийг ЗДТГ-ын касст авч зарцуулсан байна.

3.7.4 СХС-аас 2011-2013 онд зээл авсан 3 иргэний нийт 6,192.0 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн авлага барагдуулах үйл ажиллагааг аймгийн ШШГГ-аас явуулж байх хугацаанд сумын Засаг даргаас “ ... зээлээ төлж барагдуулсан тул гүйцэтгэх хуудсыг хааж өгнө үү” гэсэн хүсэлтийг албан бичгээр хүргүүлж, гүйцэтгэх ажиллагааг зогсоосноос шалтгаалж тус зээлүүд өнөөг хүртэл эргэн төлөгдөж дуусаагүй байна. Энэ нь СХС-ийн зээлийн үлдэгдэлд найдваргүй авлага үүсэх, СХС-ийн эргэлтийг удаашруулах, эх үүсвэр дутагдах эрсдэлийг үүсгэж байна. Үүнд: Иргэн Л.Оюумаагийн гоо сайхны үйл ажиллагаа эрхлэх зориулалтаар авсан 577.3 мянган төгрөгийн үлдэгдэл, С.Туяацэцэгийн оёдлын үйл ажиллагаа эрхлэх зориулалтаар авсан 5,148.7 мянган төгрөгийн, Б.Дашжамцын маж ахуй эрхлэх зориулалтаар авсан 466.0 мянган төгрөгийн төлөгдөөгүй зээлийн үлдэгдэл байна.

3.8 Аудитын гол асуудал

3.8.1 Аудитын түүврээр ЭМТ нь тайлант онд Короно вирусын халдварыг илрүүлэх түргэвчилсэн шинжилгээг нийт 554 иргэнээс авсан бөгөөд үүнээс 35 иргэн, эмнэлгийн ажилчдаас үнэ төлбөргүй шинжилгээ авсан байна. Төлбөртэй шинжилгээ өгсөн 519 иргэний 12,975.0 мянган төгрөгийн шинжилгээний төлбөр болох түргэвчилсэн оношлуурын орлогын төлбөрийг байгууллагын кассаар дамжуулаагүй буюу орлогыг нярваар хураалгаагүй, тооцоог нягтлан бодогчоор хянуулалгүй зарцуулсан байна.

3.8.2 ЭМТ нь 2021 оны 07 дугаар сарын 29-ны өдөр 543.0 мянган төгрөгийн оношлуурын төлбөрийг ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд ганцхан удаа төвлөрүүлсэн бөгөөд үлдсэн 12,432.0 мянган төгрөгийн шинжилгээний төлбөрийн орлого сумын Онцгой комисс болон ЗДТГ, ЭМТ-ийн кассаар дамжиж данс, бүртгэлд туссан эсэх талаарх анхан шатны баримт аудитын хугацаанд ирүүлээгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх,

нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хүснэгт 8. ТТЗ-ийн харьяа байгууллагуудын шилэн дансны мэдээлэл

Д/д	Байгууллагын нэр	Мэдээлбэл зохих	Мэдээлсэн	Хугацаа хоцроосон	Мэдээлээгүй
1	Засаг дарга	151	146	5	-
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	151	151	-	-
3	Засаг даргын Тамгын газар	151	148	3	-
4	Эрүүл мэндийн төв	151	130	19	2
5	Соёлын төв	151	149	2	-
	Нийт дүн	755	724	29	2

ТТЗ-ийн түвшинд нийт давхардсан тоогоор мэдээлбэл зохих 755 мэдээллээс 724 мэдээллийг хугацаанд нь 29 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээллийн мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Зүүнбүрэн сумын ТТЗ-ийн тайлант оны үйл ажиллагаанд 2,630,174.0 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 2,376,553.4 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 9.6 хувиар хэмнэсэн байна.

Харьяа байгууллагуудын төсвийн хэмнэлт:

- ИТХ-ын тайлант оны үйл ажиллагаанд 62,152.4 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 60,326.9 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 3.0 хувиар хэмнэсэн,
- ЗДТГ-ын тайлант оны үйл ажиллагаанд 503,877.2 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 481,809.1 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 4.4 хувиар хэмнэсэн,
- Соёлын төвийн тайлант оны үйл ажиллагаанд 139,810.0 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 132,266.9 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 5.4 хувиар хэмнэсэн.

Энэ нь ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: “.....батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон

хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

3.10 Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 152,005.1 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 11 албан шаардлага, 6 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 8 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Хариуцлага тооцуулах албан шаардлага	1	-	1	-	-	-	100.0
Албан шаардлага	8	70,385.8	6	43,974.8	2	26,441.0	75.0
Зөвлөмж	7	81,619.3	4	81,619.3	3	-	57.1
Нийт	16	152,005.1	11	123,149.2	5	28,855.9	68.7

Эх сурвалж: Зүүнбүрэн сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт, Зүүнбүрэн сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, холбогдох баримтууд

ЭМТ нь өмнөх аудитаар өгсөн илүү ажилласан цагийг анхан шатны баримтуудаар баталгаажуулж байх, жолоочийн тооцооны хуудсанд ирсэн, явсан болон зарцуулсан цаг, спидометрийн заалтыг бүрэн бүртгэж, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, эмийн сангийн эмийн хөдлөл өөрчлөлтийг анхан шатны баримтыг үндэслэн тухай бүр бүртгэж, программд бичилт хийж байх зөвлөмжүүдийг хэрэгжүүлэлгүйгээр давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

ЭМТ нь өмнөх аудитаар өгсөн төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлж өр төлбөр үүсгэхгүй ажиллах, эмийн сангийн орлогыг тухай бүр нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж байх албан шаардлагыг биелүүлээгүй, тайлант онд давтан гаргасан тул Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй.....нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэсэн заалтын дагуу төсвийн шууд захирагчид хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

3.11.1 Санхүүгийн тайлангийн аудитын цаг хугацаа, хүн хүчний хязгаарлагдмал байдлын улмаас ОНХС, төсвийн хөрөнгөөр гүйцэтгэгдэж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт, бүртгэл тайлагнал, гүйцэтгэлтэй холбоотой асуудлуудыг бүрэн хэмжээгээр тулган баталгаажуулсан бөгөөд харин төлөвлөлт, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлуудыг Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн, ОНХС-ийн зарцуулалтын үр дүн сэдэвт аудитаар гүнзгийрүүлэн шалгах шаардлагатай юм.

4. Аудитын илрүүлэлт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн шууд захирагчийн 6 төсвийн байгууллага, орон нутгийн төсөл, сангийн 2, нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 2 байгууллагад дүгнэлт гаргаж, 6 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Зүүнбүрэн сумын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 168,846.0 мянган төгрөгийн 28 алдаа, зөрчил илрүүлснээс 1,014.5 мянган төгрөгийн 1 алдааг аудитын явцад залруулж, 8,121.9 мянган төгрөгийн зөрчилд 8 зөрчилд төлбөрийн акт тогтоон, 46,572.7 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 10 зөрчилд албан шаардлага, 113,137.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 11 зөвлөмжийг хүргүүллээ.

Аудитад хамрагдсан харьяа 2 байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн байна.

ТТЗ-ийн түвшний аудитаар нийт 160,159.9 мянган төгрөгийн 19 алдаа, зөрчил илрүүлснээс 7,563.2 мянган төгрөгийн 5 алдаа, зөрчилд төлбөрийн акт тогтоож, 46,572.7 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 9 зөрчилд албан шаардлага, 106,024.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмжийг хүргүүллээ.

4.1 Төлбөрийн акт:

1. Тайлант онд “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн буцалтгүй тусламж”-ийг 3 албан хаагчид олгохдоо тухайн албан хаагчийн 36 сарын албан тушаалын үндсэн цалингийн дунджийг зөрүүтэй тооцоолсон болон гэрээтээр ажиллаж байсан хугацааг төрийн албанд ажилласан хугацаанд оролцуулан тооцож нийт **3,381.8** мянган төгрөг илүү олгосон байна. Үүнд:

- Сумын ЗДТГ- БОУБ С.Эрдэнэчимэгт 447.6 мянган төгрөг, Санхүү, албаны дарга С.Цэлмэгт 444.4 мянган төгрөг, жижүүр Б.Сүхбаатарт 808.1 мянган төгрөг,
- Сумын соёлын төвийн дуу хөгжмийн багш Н.Нарангэрэлд 1,131.9, үйлчлэгч Л.Ариунаад 549.8 мянган төгрөг.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолоор

баталсан “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ын 2.1 дэх “Нэг удаагийн буцалтгүй тусламж тооцох үндсэн цалингийн хэмжээг тогтоохдоо тухайн албан тушаалын үндсэн цалингийн сүүлийн 3 жилийн дунджаар тооцно”, 3.1 дэх “Төрийн албан хаагчийн төрийн албанд ажилласан хугацаанд дараах хугацааг оруулж тооцно” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон нэг удаагийн буцалтгүй тусламжийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

2. ИТХ нь нарийн бичгийн дарга Ж.Нямсүрэнд **200.0** мянган төгрөгийн албан томилолтын зардлыг давхардуулан олгосон /ЗГХЭГ, Удирдлагын академи, БНСУ-ын Нутгийн удирдлагын хөгжлийн институтийн хамтарсан “Төрийн албан хаагчдын чадавхыг бэхжүүлэх” чиглэлийн хүрээнд 4 өдрийн сургалтыг зохион байгуулж, албан томилолтын зардлыг тооцож олгосон/ байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Давхардуулан олгосон албан томилолтын зардлыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

3. ЭМТ нь Ковид-19 өвчнийг илрүүлэх оношлуурын шинжилгээний төлбөрийн орлогын тооцоог тухай бүр хийж баталгаажуулаагүйгээс **3,082.0** мянган төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 35 дугаар зүйлийн 35.2 дахь “Төсвийн байгууллага нь төвлөрүүлсэн төсвийн орлого болон өөрийн үйл ажиллагааны орлогыг Төрийн сангийн нэгдсэн дансанд саадгүй байршуулна” гэсэн заалтуудыг зөрчсөн ба санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дутуу төвлөрүүлсэн оношлуурын орлогыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоож, албан үүргээ хангалтгүй гүйцэтгэсэн, Ковид 19-ын оношлуурын орлого, бүрдүүлэлт дэх бүртгэлээрх хяналтыг сулруулсан тул хууль хяналтын байгууллагад шилжүүлэн, шалгуулах.

4. ЭМТ нь төлбөр тооцоог тухай бүр хийж баталгаажуулаагүйгээс эмийн сангийн **899.4** мянган төгрөгийн эмийн орлогыг дутуу төвлөрүүлсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг зөрчсөн ба санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дутуу төвлөрүүлсэн эмийн орлогыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

4.2 Албан шаардлага

Эрүүл мэндийн төв :

1. ЭМТ-ийн магадлан итгэмжлэлийн хугацааг сунгуулаагүй, ЭМДС-аас санхүүжилт аваагүйгээс шалтгаалан эм хангамжийн байгууллагуудад **5,697.7** мянган төгрөгийн эмийн төлбөрийн өр төлбөр үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог **хянах**, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдах, төлбөр тооцоог урьдчилан хянах замаар авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах албан шаардлага хүргүүлэх.

2. Тайлант оны батлагдсан төсвийн хүрээнд аймгийн ЭМГ-аас тендерийн эмийг хүлээн авч зарцуулсан атал эмийн батлагдсан төсвийг хэтрүүлж 7,484.2 мянган төгрөгийн, ЭМДС-аас санхүүжилт авч чадаагүйгээс Ковид 19 -ын багцын 3,665.2 мянган төгрөгийн зэрэг нийт **11,149.4** мянган төгрөгийн эмийг ЭЭС-аас авсан боловч төлбөрийг барагдуулаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь “**батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах**”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “**Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргах үндэслэл болно**” гэсэн заалтуудыг зөрчсөн ба санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргаж байх албан шаардлага хүргүүлэх

3. Өмнөх оны зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс тайлант оны эмийн сангийн **16,434.0** мянган төгрөгийн кассын орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд орлого орсон тухай бүр бус бөөн дүнгээр төвлөрүүлсэн байгаа нь нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалын 1-р хавсралтаар баталсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 3.12 дахь “**Эрх бүхий ажилтан хураасан орлогоо өөрийн байгууллагын бүртгэлийн дансанд ажлын 1 хоногт багтаан тушааж сар бүрийн эцэст зарагдсан тасалбарын бүртгэл болон орлого цуглуулсан баримтын (зарагдсан тасалбараас өөрт үлдэх хувь) тооцоог гаргаж, тайланг тушаана**” гэсэн заалтыг зөрчсөн ба санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Кассын орлогыг тухай бүр нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж байх албан шаардлага хүргүүлэх.

4. Хөнгөлөлттэй эмийн жор зөрүүтэй бичигдсэнээс шалтгаалж 647.1 мянган төгрөгийн ЭМДС-ийн санхүүжилт дутуу авсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь *“дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”* ба санхүүгийн тайлангийн *“Нийсэн бөгөөд зохистой байх”* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөнгөлөлттэй эмийн жорын тооцоог үнэн зөв илэрхийлж, хянан баталгаажуулах замаар ЭМДС-ийн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлэх албан шаардлага хүргүүлэх.

5. Дарга О. Халиуны эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацаа дууссан байхад тайлант оны 9-12 дугаар саруудад их эмчийн албан тушаал хавсран ажилласны **837.7** мянган төгрөгийн нэмэгдэл цалин олгосон байна. Энэ нь Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх *“Эмнэлгийн тусламж, үйлчилгээг мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий эмнэлгийн мэргэжилтэн үзүүлэх бөгөөд зөвхөн зөвшөөрөл олгосон төрлөөр тусламж, үйлчилгээ үзүүлнэ”* гэсэн заалтыг зөрчсөн ба санхүүгийн тайлангийн *“Нийсэн бөгөөд зохистой байх”* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацааг үндэслэж нэмэгдэл цалинг олгож байх албан шаардлага хүргүүлэх.

6. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг биелүүлэлгүйгээр зөрчлийг давтан гаргаж, "Нэмэгдэл хөлс тооцож олгох" хуудсаар баталгаажуулаагүй болон албан тушаалын ажлын байрны тодорхойлолтод заасан ажил үүргээ гүйцэтгэсэн дарга О.Халиун *Их эмч хавсран ажилласан*-д **5,899.3** мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдэл хөлс олгосон, жолоочийн тооцооны хуудасгүй нийт **5,907.5** мянган төгрөгийн шатахуун зарцуулсан. / Үүнээс дарга О.Халиунд 4,204.5 мянган төгрөгийн дизель түлш олгосон / байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д *“Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”*, Сангийн сайдын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт *“Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”*-ын 3-т Нэмэгдэл хөлс олгох: *“Төрийн албан хаагч энэ журмын хавсралтаар баталсан “Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас”-ны дагуу илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласан үндэслэл, гүйцэтгэсэн ажлын гол агуулга, нэмэгдүүлсэн цалин хөлсний тооцоог нэгжийн даргаар хянуулж баталгаажуулсны үндсэн дээр байгууллагын дарга зөвшөөрөл олгосны дараа санхүүд хүргүүлнэ.”* Гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн ба санхүүгийн тайлангийн *“Нийцсэн бөгөөд зохистой байх”* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Жолоочийн тооцооны хуудас болон илүү цагийн нэмэгдэл хөлс олгох маягт зэрэг анхан шатны баримтуудыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх албан шаардлага хүргүүлэх.

7. Дарга О.Халиун нь байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллуулаагүй, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, төсөв санхүүгийн их хэмжээний материаллаг алдаа зөрчил гаргасан зэргээр албан үүргээ хангалтгүй гүйцэтгэсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан үүргээ хангалтгүй гүйцэтгэсэн, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй зэрэг алдаа зөрчлийг давтан гаргасан дарга О.Халиунд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэх.

4.3 Зөвлөмж

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 106,024.0 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 6 зөвлөмж өглөө.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Төсвийн төлөвлөлтийг бодит судалгаа, мэдээлэл дээр үндэслэн зардлын зүйл, эдийн засгийн ангиллаар нь үнэн зөв төлөвлөөгүйгээс ЗДТГ нь бичиг хэргийн зардлаас 350.0 мянган төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд, ЭМТ нь хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас 450.0 мянган төгрөгийг улсын мэдээллийн маягт хэвлэх зардалд зэрэг нийт **900.0** мянган төгрөгийг тус тус санхүүжүүлсэн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална”, 5.1.2 дахь “Төсвийн иж бүрэн, **үнэн зөв** байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг зөрчиж байгаа тул зардлыг бодит тооцоо судалгаан дээр үндэслэж, үнэн зөв төлөвлөж, хэрэгжүүлж байх.

2. Анхан шатны баримтын бүрдүүлэлттэй холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Тайлант онд ИТХ нь 2,127.8 мянган төгрөгийн, ЗДТГ нь 27,427.8 мянган төгрөгийн, Соёлын төв нь 2,382.6 мянган төгрөгийн, ЭМТ нь 67,417.5 мянган төгрөгийн зэрэг нийт **99,355.5** мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр,

тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасныг зөрчсөн ба “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Цаашид холбогдох хууль тогтоомжийн дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж, ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэх.

3. Нягтлан бодох бүртгэл хөтлөлтэй холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт: ЗДТГ-ын үндсэн хөрөнгийн дансанд 1,399.0 мянган төгрөгийн бараа материал бүртгэсэн, бараа материалын дансанд 825.3 мянган төгрөгийн тавьж олгосон материал бүртгэлтэй байгаа нь УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө”-ийн 13 (б)-д “Нэгээс дээш тайлангийн хугацааны туршид ашиглагдахаар хүлээгдэж байгаа хөрөнгө юм”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын Бараа материал: “Бараа материалыг ажил үйлчилгээнд ашиглахаар тавьж олгоход: Дт. Зардал /Зардлын зүйлээр/, Кт. Хангамжийн материалын холбогдох дэд данс” гэсэн заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн “Ангилал”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

3.1.2 Зөвлөмж: Дээрх хөрөнгүүдийг 2022 оны эхний хагас жилд багтааж зөв ангилан, залруулж бүртгэх.

3.2.1 Илрүүлэлт: ЭМТ нь 3,644.2 мянган төгрөгийн бараа материалыг жижиг мөнгөн сангийн дансаар бус албан хаагчдын харилцах дансаар дамжуулж худалдан авсан байгаа нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалын 1-р хавсралтаар баталсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 2.2 дахь “Төсвийн байгууллага нь арилжааны банкны төлбөрийн картын дансанд байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай бэлэн мөнгийг төрийн сангаас баталсан хязгаар/ЖМС/-ын дотор шилжүүлэн авч болох бөгөөд гадаад, дотоод албан томилолт, гадаад зочны зардал, тэтгэмж, урамшуулал, шагналыг батлагдсан төсвийн хүрээнд шилжүүлэн авч болно” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2.2 Зөвлөмж: ЭМТ нь арилжааны банканд төлбөрийн картын данс нээлгэж батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай бэлэн мөнгийг шилжүүлэн авч зарцуулж байх.

4. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал

4.1 Илрүүлэлт: ТТЗ-ийн харьяа байгууллагууд нь Шилэн дансанд мэдээлбэл зохих 755 мэдээллээс 29 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээллийг мэдээлээгүй байна. Үүнд: Мэдээлбэл зохих мэдээллээс ТТЗ-5, ЗДТГ-3, Соёлын төв 2 мэдээллийг хугацаа хоцроосон, ЭМТ нь 19 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээллийг мэдээлээгүй байна.

4.2 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1- 6.4 дэх заалтуудыг мөрдөж, холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

Д/д	Зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Акт				Үүнээс				Зөвлөмж		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Албан шаардлага		Хариуцлага тооцох		Тоо	Дүн	Тоо	Дүн	
						Тоо	Дүн	Тоо	Дүн					
Санхүүгийн тайлангийн асуудлаар														
1	Албан үүргээ хангалтгүй гүйцэтгэж, алдаа зөрчлийг давтан гаргасан ЭМТ-ийн дарга О.Халиунд сахилгын шийтгэл ногдуулах.	1	-											
2	Тайлант онд ТТЗ-ийн харьяа байгууллагууд бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй	1	99,355.5										1	99,355.5
3	ИТХ-ын нарийн бичгийн даргад албан томилолтын зардлыг давхардуулан олгосон.	1	200.0	1	200.0									
4	ЗДТГ нь 2019 онд тэтгэвэрт гарахаар төрийн албанаас чөлөөлөгдөж гэрээгээр ажиллаж байсан 4 албан хаагчид төрийн албан хаагчид олгох нэг удаагийн тэтгэмж урамшууллыг илүү тооцож олгосон.	1	1,700.1	1	1,700.1									
5	ЗДТГ-ын үндсэн хөрөнгийн дансанд бараа материал бүртгэлтэй, бараа материалын дансанд тавьж олгосон материалууд бүртгэлтэй байна.	1	2,224.3										1	2,224.3
6	ЗДТГ нь төсвийн төлөвлөлтийг бодит судалгаа, мэдээлэл дээр үндэслэн зардлын зүйл, эдийн засгийн ангиллаар нь үнэн зөв төлөвлөөгүй.	1	350.0											
7	ЭМТ нь Ковид 19 -ын багцын эмийг эмийн сангаас авч, иргэдэд олгосон боловч ЭМДС-с санхүүжилт аваагүй	1	3,665.2			1	3,665.2							
8	ЭМТ нь төлбөр тооцоог тухай бүр хийж баталгаажуулаагүйгээс Ковид-19 өвчнийг илрүүлэх оношлуурын орлогыг дутуу төвлөрүүлсэн.	1	3,082.0	1	3,082.0									

Зүүнбүрэн сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

9	ЭМТ нь эмийн сангийн кассар авсан орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд орлого орсон тухай бүр бус бөөн дүнгээр төвлөрүүлсэн.	1	16,434.0		1	16,434.0			
10	ЭМТ-ийн даргад эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацаа дууссан байхад их эмчийн албан тушаал хавсран ажилласны нэмэгдэл цалин олгосон.	1	837.7		1	837.7			
11	ЭМТ нь "Нэмэгдэл хөлс тооцож олгох" хуудсаар баталгаажуулаагүй болон албан тушаалын ажлын байрны тодорхойлолтод заасан ажил үүргээ гүйцэтгэсэн дарга О.Халиунд илүү цагийн нэмэгдэл хөлс олгосон.	1	5,899.3		1	5,899.3			
12	ЭМТ нь анхан шатны баримтын бүрдэлгүй буюу жолоочийн тооцооны хуудасгүйгээр шатахууны зарцуулалтын ажил гүйлгээг гүйцэтгэсэн.	1	5,907.5		1	5,907.5			
13	ЭМТ нь эм хангамжийн байгууллагуудад эмийн төлбөрийн ер төлбөр үүсгэсэн	1	5,697.7		1	5,697.7			
14	ЭМТ нь хөнгөлөлтэй эмийн жор зөрүүтэй бичигдсэнээс шалтгаалж ЭМДС-ийн санхүүжилт дутуу төвлөрсөн.	1	647.1		1	647.1			
15	ЭМТ нь бараа материалыг жижиг мөнгөн сангийн дансаар бус албан хаагчдын харилцах дансаар дамжуулж худалдан авсан.	1	3,644.2				1	3,644.2	
16	ЭМТ нь эмийн батлагдсан төсвийг хэтрүүлж ЭЭС-аас авсан эмийн төлбөрийг барагдуулаагүй.	1	7,484.2		1	7,484.2			
17	Эмийн сангийн эмийн орлого дутуу төвлөрүүлсэн байна.	1	899.4	1	899.4				
18	ЭМТ нь төсвийн төлөвлөлтийг бодит судалгаа, мэдээлэл дээр үндэслэн зардлын зүйл, эдийн засгийн ангиллаар нь үнэн зөв төлөвлөөгүй.	1	450.0				1	450.0	

Зүүнбүрэн сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

19	Соёлын төв нь 2019 онд тэтгэвэрт гарахаар төрийн албанаас чөлөөлөгдөж гэрээгээр ажиллаж байсан 2 албан хаагчид төрийн албан хаагчид олгох нэг удаагийн тэтгэмж урамшууллыг илүү тооцож олгосон.	1	1,681.7	1	1,681.7								
ДҮН		19	169,509.9	5	16,913.2	8	46,572.7	1	-	5	106,024.0		

Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал

1	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй	1										1	-
2	ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлээгүй	1				1							
	ДҮН	2	-	-	-	1	-	-	-	1	-	1	-
	НИЙТ ДҮН	21	169,509.9	5	16,913.2	9	46,572.7	1	-	6	106,024.0		